



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/78-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: Ukhaanbilegm@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	113
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	124
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	135
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	156
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	157







2.1. Оршил

Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Баяртогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь “Усны экологийн системийг хадгалж, ухаалаг менежментийг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Онон-Улз голын сав газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд АСОЛУОС программ хангамж ашигладаг байна.

Онон-Улз голын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Онон-Улз голын сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 178,317.5 мянган төгрөгөөс тооцон 3,566.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,617.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөлтөөс өссөн үзүүлэлттэй байгаа нь санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,585.5 мянган төгрөгөөр буурсан байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/



Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	3,443.2	3,443.2	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	8,055.5	8,571.4	515.8
Үндсэн хөрөнгө	138,953.7	138,953.7	0.0
Элэгдэл	-51,029.3	-64,130.7	-13,101.3
Нийт хөрөнгө	4,528,350.6	4,880,484.0	
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	214,914.9	214,914.9	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	99,423.1	86,837.6	-12,585.7

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос өссөн нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан материалын үлдэгдлээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлээс шалтгаалжээ. Тайлант онд үндсэн хөрөнгө нэмэгдээгүй тул элэгдлийн дүнгээр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл нь өмнөх оноос хөдлөөгүй нь авлагаа барагдуулж ажиллаагүйтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо хөдлөөгүй нь өглөгийн үлдэгдэлгүй, үндсэн хөрөнгө нэмэгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Онон-Улз голын сав газрын захиргаа нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 164,644.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 154,258.6 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байна. Энэ нь санхүүжилт буурч ирсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас 9,507.0 мянган төгрөгийн, Байгаль орчин уур амьсгалын сангаас 1,414.2 мянган төгрөгийн санхүүжилт авч нэмэлт төсвийг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс төслийн үйл ажиллагааны хүрээнд бичиг хэрэгт 1,447.0 мянган төгрөг, шатахуун 2,644.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 4,343.2 мянган төгрөг, томилот 822,0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,164.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 500,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.



2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,041.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,443.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,323.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,275.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3,443.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,323.2 мянган төгрөгийн зөрчил төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Өнгөрсөн жилийн аудитаар авлагын үлдэгдлийг барагдуулах өмнө жилийн аудитын зөвлөмжийн дагуу хуулийн байгууллагад хандаж хариу нь гараагүй байсан тул зөвлөмж өгөөгүй орхисон. Уг авлагын үлдэгдлийг тайлант онд барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Түлээ 1,323.0 мянган төгрөгийн үлдэгдлийг нөөцлөн авч он дамжуулан зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43.5 дахь " Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр жил дамжуулан зарцуулахгүй." гэсэн заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 2,275.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Онон-Улз голын сав газрын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагын үлдэгдлийг барагдуулж ажиллах зөвлөмжийн биелэлт 0.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт



Онон-Улз голын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шатах тослох, түлш халаалтын материалаас 2,275.0 мянган төгрөгийн түлээг зарлагдахдаа тээвэр шатахууны зардлын дансаар зарлагдсан нь Сангийн сайдын 2007 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ хөтлөлтийн дансны заавартай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэнээр хэрэглэгчдэд ялгарч харагдахгүй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны заавар мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,498,763.00</u>	<u>12,014,633.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	3,443,200.00	3,443,200.00
335	Бусад авлага	3,443,200.00	3,443,200.00
3351	Байгууллагаас авах авлага	3,443,200.00	3,443,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,055,563.00	8,571,433.00
351	Түүхий эд материал	2,578,500.00	4,049,250.00
35110	Тусгай зориулалттай материал	2,578,500.00	4,049,250.00
354	Хангамжийн материал	5,477,063.00	4,522,183.00
35410	Бичиг хэргийн материал	376,250.00	723,370.00
35420	Аж ахуйн материал	2,475,813.00	2,475,813.00
35440	Түлш, шатах тослох материал	2,625,000.00	1,323,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,924,419.71</u>	<u>74,823,032.71</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	87,924,419.71	74,823,032.71
392	Биет хөрөнгө	81,924,419.71	68,823,032.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,125,151.00	63,125,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-4,208,343.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,760,250.00	27,760,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,579,767.02	-25,206,475.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,146,407.42	32,146,407.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,112,872.04	-28,524,779.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,381,980.13	8,381,980.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,796,729.78	-4,651,157.74
393	Биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.00	-1,540,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>99,423,182.71</u>	<u>86,837,665.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>99,423,182.71</u>	<u>86,837,665.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	99,423,182.71	86,837,665.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,914,999.51	214,914,999.51
51101	Өмч: - төрийн	214,914,999.51	214,914,999.51
512	Хуримтлагдсан үр дүн	-115,491,816.80	-128,077,333.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-115,491,816.80	-115,491,816.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-12,585,517.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>99,423,182.71</u>	<u>86,837,665.71</u>



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	158,177,481.00	168,266,186.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	158,177,481.00	168,266,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	149,614,400.00	157,344,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	149,614,400.00	157,344,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,563,081.00	10,921,286.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,563,081.00	10,921,286.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	178,317,528.41	180,851,703.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,317,528.41	180,851,703.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,183,831.27	177,765,462.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,273,197.00	115,025,394.16
210101	Үндсэн цалин	71,196,015.00	77,857,700.00
210102	Нэмэгдэл	32,395,132.00	31,132,494.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,682,050.00	6,035,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,007,226.86	14,490,800.22
210201	Тэтгэврийн даатгал	8,732,199.30	10,003,581.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,409.00	1,148,657.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	893,096.00	918,927.03
210204	Ажилгүйдлийн даатгал	212,701.00	219,968.80
210205	Эрүүл мэндийн даатгал	2,093,821.56	2,199,665.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,574,079.00	11,345,231.00
210301	Гэрэл, цахилгаан	6,598,079.00	5,593,500.00
210302	Түлш, халаалт	1,700,000.00	405,731.00
210304	Байрны түрээс	3,276,000.00	5,346,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,483,125.00	16,799,746.00
210401	Бичиг хэрэг	786,225.00	2,582,280.00
210402	Тээвэр, шатахуун	5,554,900.00	8,474,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,300.00	993,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	148,700.00	4,748,786.00
2105	Нормативт зардал	364,300.00	62,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	364,300.00	62,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	258,700.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	258,700.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,700.00	3,381,510.00
210702	Дотоод албан томилолт	2,562,700.00	3,381,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,024,500.00	1,399,944.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00	618,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	268,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	117,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,300.00	97,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00



210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
210807	Газрын төлбөр	00.00	22,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,636,003.41	15,260,387.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,563,081.00	1,164,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	995,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,577,922.41	13,101,387.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,133,697.14	3,086,240.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,133,697.14	3,086,240.62
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,133,697.14	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,086,240.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-20,140,047.41	-12,585,517.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76,221,345.02	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	76,221,345.02	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-76,221,345.02	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-96,361,392.43	-12,585,517.00

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	158,177,481.00	168,266,186.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	158,177,481.00	168,266,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	149,614,400.00	157,344,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	149,614,400.00	157,344,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,563,081.00	10,921,286.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,563,081.00	10,921,286.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	158,177,481.00	168,266,186.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158,177,481.00	168,266,186.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,043,783.86	165,179,945.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,273,197.00	115,025,394.16
210101	Үндсэн цалин	71,196,015.00	77,857,700.00
210102	Нэмэгдэл	32,395,132.00	31,132,494.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,682,050.00	6,035,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,007,226.86	14,490,800.22
210201	Тэтгэврийн даатгал	8,732,199.30	10,003,581.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,409.00	1,148,657.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	893,096.00	918,927.03
210204	Ажилгүйдлийн даатгал	212,701.00	219,968.80
210205	Эрүүл мэндийн даатгал	2,093,821.56	2,199,665.48



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,499,079.00	12,668,231.00
210301	Гэрэл, цахилгаан	6,598,079.00	5,346,000.00
210302	Түлш, халаалт	2,625,000.00	1,976,231.00
210304	Байрны түрээс	3,276,000.00	5,346,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,638,100.00	15,074,166.00
210401	Бичиг хэрэг	963,100.00	2,410,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,554,900.00	6,199,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,300.00	993,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,126,800.00	5,470,186.00
2105	Нормативт зардал	624,500.00	624,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	356,400.00	356,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,700.00	3,381,510.00
210702	Дотоод албан томилолт	2,562,700.00	3,381,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,024,500.00	1,399,944.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00	618,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	268,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	117,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,300.00	97,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
210807	Газрын төлбөр	00.00	22,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,058,081.00	2,159,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,563,081.00	1,164,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	995,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,133,697.14	3,086,240.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,133,697.14	3,086,240.62
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,133,697.14	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,086,240.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00



10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
----	---	-------	-------

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	00.00	-115,491,816.80	99,423,182.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,914,999.51	00.00	-115,491,816.80	99,423,182.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-12,585,517.00	-12,585,517.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	00.00	-128,077,333.80	86,837,665.71

/төгрөг/

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164,644,900.00	154,258,659.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,644,900.00	154,258,659.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164,644,900.00	154,258,659.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,828,300.00	115,025,394.16
210101	Үндсэн цалин	77,857,700.00	77,857,700.00
210102	Нэмэгдэл	38,796,000.00	31,132,494.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,174,600.00	6,035,200.00



2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,353,600.00	14,490,800.22
210201	Тэтгэврийн даатгал	10,440,400.00	10,003,581.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,228,300.00	1,148,657.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	982,600.00	918,927.03
210204	Ажилгүйдлийн даатгал	245,700.00	219,968.80
210205	Эрүүл мэндийн даатгал	2,456,600.00	2,199,665.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,672,000.00	12,668,231.00
210301	Гэрэл, цахилгаан	5,346,000.00	5,346,000.00
210302	Түлш, халаалт	1,980,000.00	1,976,231.00
210304	Байрны түрээс	5,346,000.00	5,346,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,638,900.00	6,638,890.00
210401	Бичиг хэрэг	963,300.00	963,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,554,900.00	3,554,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,800.00	993,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,126,900.00	1,126,900.00
2105	Нормативт зардал	624,500.00	624,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	356,400.00	356,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,700.00	2,559,500.00
210702	Дотоод албан томилолт	2,562,700.00	2,559,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,113,500.00	1,399,944.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,475,000.00	618,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.00	268,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	117,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	138,600.00	97,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
210807	Газрын төлбөр	24,700.00	22,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,000.00	495,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	495,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	164,644,900.00	157,344,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	164,644,900.00	157,344,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	164,644,900.00	157,344,900.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00